



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 22-өдөр

Дугаар 4/678

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит XX хуралдааны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хүүхэд эрхэм хэрэглэгч” аяны хүрээнд зохион байгуулж буй, хүүхдийг аливаа донтолтоос сэргийлэх, сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний талаарх мэдээллийг албан байгууллага, иргэд, олон нийтэд хүргэхэд чиглэсэн багц хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардалд 7,500,000 (долоон сая таван зуун мянга) төгрөг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 7,500,000 (долоон сая таван зуун мянга) төгрөгийг “Засаг дарга” дансны “Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний” зардлаас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх) зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ